



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 08 сарын 23 өдөр

Дугаар А/610

Булган сум

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1 дэх заалт, мөн хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.6 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 08 дугаар сарын 04-ны өдрийн XVII/01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.2023 оны бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан зарим төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах эрхийг хавсралтад заагдсаны дагуу сум, байгууллагуудад олгосугай.

2.Эрх шилжүүлсэн төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, журмын хүрээнд Төрийн худалдан авах ажиллагааны www.tender.gov.mn цахим системээр 2023 оны 10 дугаар сарын 01-ны дотор зохион байгуулж, гэрээ байгуулан, хүлээн авахыг сум, байгууллагын дарга нарт үүрэг болгосугай.

3.Эрх шилжүүлсэн төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаанд мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлж, хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн газрын дарга (Т.Баттулга)-д үүрэг болгосугай.

4.Хавсралтад тусгагдсан төсөл арга хэмжээг холбогдох хууль, журмын дагуу санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Д.Батцогт)-д зөвшөөрсүгэй.


ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

6323030660

Аймгийн Засаг даргын 2023 оны 08 дугаар сарын 23-ны
 өдрийн 4/10 дугаар захирамжийн хавсралт



№	Төсөл арга хэмжээний нэрс	Нийт төсөвт өртөг	Тухайн онд санхүүжүүлэх төсөвт өртөг	ХАА-нд мөрдөх журам	Тайлан мэдээ ирүүлэх хугацаа	Эрх шилжүүлсэн сумдын дарга
Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт						
1	Орон сууцны 314 дүгээр байрны дээврийн засвар тохижилт (Булган сум)	125,000.0	125,000.0	НТШ	Сар бүрийн 25-ны өдөр	Булган сумын Засаг дарга П.Нөхөрлөлбаяр
2	Соёлын төвийн лед дэлгэц (Бугат сум)	45,000.0	45,000.0	ХА	Сар бүрийн 25-ны өдөр	Бугат сумын Засаг дарга Х.Ууганбаяр
3	Тусгай зориулалтын тээврийн хэрэгсэл худалдан авах (Булган мээж ОНӨХХК)	85,000.0	85,000.0	ХА	Сар бүрийн 25-ны өдөр	(Булган мээж ОНӨХХК)-ийн захирал Г.Ганбаатар
4	Төсвийн байгууллагуудын сантехникийн засвар (Баяннуур сум)	80,000.0	80,000.0	ХА	Сар бүрийн 25-ны өдөр	Баяннуур сумын Засаг дарга Л.Одончимэг
5	Гатлага онгоц худалдан авах (Хутаг-Өндөр сум)	35,000.0	35,000.0	ХА	Сар бүрийн 25-ны өдөр	Хутаг-Өндөр сумын Засаг дарга П.Лхагва-Очир
6	Соёлын төвийн лед дэлгэц (Хутаг-Өндөр сум)	48,000.0	48,000.0	ХА	Сар бүрийн 25-ны өдөр	Хутаг-Өндөр сумын Засаг дарга П.Лхагва-Очир
НИЙТ ДҮН		410,000.0	410,000.0			